



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Батцэнгэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/124/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.open.audit.mn Архангай аймаг 2026 он	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Грут финанс Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж Утас: 77721628 Цахим хаяг: Byambadorj@growthfinance.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangaiaudit@gov.mn

2026.02.25 № 87
танай _____-ны № _____-т

БАТЦЭНГЭЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Т.БАДАМГАРАВ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Батцэнгэл сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх "сургуулийн өмнөх боловсрол" хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 935,010.7 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 1,015,896.6 мянган төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 үндсэн зорилтын хүрээнд 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Данс код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	186,016,058.30	94,204,195.38
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	112,314,994.06	31,429,077.14
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	112,314,994.06	31,429,077.14
31211	Төрийн сангийн харилцах	112,314,994.06	31,429,077.14
35	БАРАА МАТЕРИАЛ	73,701,064.24	62,775,118.24
351	Түүхий эд материал	2,566,150.00	24,000.00
35130	Эм боох материал	2,566,150.00	24,000.00
354	Хангамжийн материал	71,134,914.24	62,751,118.24
35410	Бичиг хэргийн материал	90,000.00	-
35420	Аж ахуйн материал	54,284,613.44	54,094,436.44
35440	Түлш, шатах тослох материал	955,300.00	450,000.00
35470	Бусад хангамжийн материал	15,805,000.80	8,206,681.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,158,899,306.82	3,090,152,446.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,158,899,306.82	3,090,152,446.00
392	Биет хөрөнгө	3,153,149,306.82	3,084,402,446.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,163,581,620.55	3,163,581,620.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	(91,964,334.52)	(148,008,853.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	86,962,010.50	91,764,110.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(46,304,831.49)	(61,590,741.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	77,810,469.30	89,540,227.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,111,327.52)	(52,059,617.78)
39217	Ном	1,175,700.00	1,175,700.00
393	Биет бус хөрөнгө	5,750,000.00	5,750,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.00)	(300,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,750,000.00	5,750,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,344,915,365.12	3,184,356,641.38
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,344,915,365.12	3,184,356,641.38
51	Засгийн газрын хувь оролцоо	3,344,915,365.12	3,184,356,641.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	275,492,929.25	275,492,929.25
512	Хуримтлагдсан үр дүн	3,066,838,105.07	2,906,279,381.33
51210	Өмнөх үеийн үр дүн	3,066,838,105.07	3,066,838,105.07
51220	Тайлант үеийн үр дүн	-	(160,558,723.74)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,584,330.80	2,584,330.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,344,915,365.12	3,184,356,641.38

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	824,380,520.00	967,110,658.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,174,120.00	20,493,458.00
120	Нийтлэг татварын бус орлого	22,174,120.00	20,493,458.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,174,120.00	20,493,458.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	126,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,000,000.00	105,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн хөрөнгө	9,048,120.00	11,729,758.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан Бараа материал	-	8,658,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	802,206,400.00	946,617,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	763,416,000.00	900,883,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	763,416,000.00	900,883,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,790,400.00	45,733,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,790,400.00	45,733,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	897,140,725.09	1,123,621,681.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	897,140,725.09	1,123,621,681.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	889,935,925.09	1,111,910,132.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	580,856,589.50	789,296,572.92
210101	Үндсэн цалин	370,998,761.58	499,813,987.09
210102	Нэмэгдэл	170,961,514.73	243,303,940.34
210104	Урамшуулал	38,896,313.19	46,178,645.49
2102	Ажил олгогч төлөх нийгмийн даатгал	75,591,316.68	90,193,100.00
210201	Тэтгэврийн даатгал	51,385,216.68	61,326,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,051,600.00	7,222,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,025,700.00	3,610,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,025,700.00	3,610,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,103,100.00	14,424,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	36,694,400.00	31,471,751.00
210301	Гэрэл, цахилгаан	11,696,306.00	12,532,651.00
210302	Түлш, халаалт	24,413,044.00	17,958,000.00
210303	Цэвэр, бохир ус	585,050.00	981,100.00
2105	Нормативт зардал	63,838,315.00	70,404,836.00
210502	Хоол, хүнс	63,838,315.00	70,404,836.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,896,000.00	2,185,000.00
210604	Урсгал засвар	1,896,000.00	2,185,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	2,121,952.00	3,112,148.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,121,952.00	3,112,148.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	128,937,351.91	125,246,724.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,606,378.71	34,738,546.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,554,800.00	5,328,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	90,776,173.20	85,179,578.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,204,800.00	11,711,549.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,078,800.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,078,800.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	126,000.00	11,711,549.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	126,000.00	11,711,549.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(72,760,205.09)	(156,511,023.74)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	4,047,700.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	4,047,700.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(4,047,700.00)

Архангай аймгийн Батцэнгэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(72,760,205.09)	(160,558,723.74)
---	-------------------------	-----------------	------------------

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	815,332,400.00	946,722,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,126,000.00	105,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,126,000.00	105,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,126,000.00	105,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	126,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,000,000.00	105,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	802,206,400.00	946,617,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	763,416,000.00	900,883,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	763,416,000.00	900,883,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,790,400.00	45,733,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,790,400.00	45,733,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	809,531,361.89	1,022,806,016.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	809,531,361.89	1,022,806,016.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	802,326,561.89	1,011,094,467.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	580,856,589.50	789,191,572.92
210101	Үндсэн цалин	370,998,761.58	477,136,346.53
210102	Нэмэгдэл	170,961,514.73	265,876,580.90
210104	Урамшуулал	38,896,313.19	46,178,645.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,591,316.68	90,193,100.00
210201	Тэтгэврийн даатгал	51,385,216.68	61,326,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,051,600.00	7,222,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,025,700.00	3,610,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,025,700.00	3,610,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,103,100.00	14,424,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,190,400.00	31,721,751.00
210301	Гэрэл, цахилгаан	11,696,306.00	12,532,651.00
210302	Түлш, халаалт	23,709,044.00	18,408,000.00
210303	Цэвэр, бохир ус	785,050.00	781,100.00
2105	Нормативт зардал	64,151,085.00	70,404,836.00
210502	Хоол, хүнс	64,151,085.00	70,404,836.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,600,000.00	2,300,000.00
210604	Урсгал засвар	2,600,000.00	2,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,401,952.00	3,849,648.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,401,952.00	3,849,648.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,535,218.71	23,433,560.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,514,318.71	18,194,960.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,020,900.00	5,238,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,204,800.00	11,711,549.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,078,800.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,078,800.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	126,000.00	11,711,549.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	126,000.00	11,711,549.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,801,038.11	(76,083,816.92)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,000,000.00	4,802,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,000,000.00	4,802,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,000,000.00	4,802,100.00
223001	Бусад хөрөнгө	3,000,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	4,802,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,000,000.00)	(4,802,100.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,801,038.11	(80,885,916.92)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	109,513,955.95	112,314,994.06

Архангай аймгийн Батцэнгэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	112,314,994.06	31,429,077.14
----	---	----------------	---------------

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	275,492,929.25	2,584,330.80	3,066,838,105.07	3,344,915,365.12
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	275,492,929.25	2,584,330.80	3,139,598,310.16	3,417,675,570.21
Тайлант үеийн үр дүн	-	-	(72,760,205.09)	(72,760,205.09)
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	275,492,929.25	2,584,330.80	3,066,838,105.07	3,344,915,365.12
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	275,492,929.25	2,584,330.80	3,066,838,105.07	3,344,915,365.12
Тайлант үеийн үр дүн	-	-	(160,558,723.74)	(160,558,723.74)
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	275,492,929.25	2,584,330.80	2,906,279,381.33	3,184,356,641.38

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,052,378,200.00	1,015,896,567.92	36,481,632.08	96.53
УРСГАЛ ЗАРДАЛ	1,052,378,200.00	1,015,896,567.92	36,481,632.08	96.53
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,052,378,200.00	1,015,896,567.92	36,481,632.08	96.53
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	798,903,300.00	789,191,572.92	9,711,727.08	98.78
Үндсэн цалин	508,569,200.00	477,136,346.53	31,432,853.47	93.82
Нэмэгдэл	273,948,300.00	265,876,580.90	8,071,719.10	97.05
Урамшуулал	16,385,800.00	46,178,645.49	(29,792,845.49)	281.82
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,451,400.00	90,193,100.00	9,258,300.00	90.69
Тэтгэврийн даатгал	67,463,400.00	61,326,100.00	6,137,300.00	90.90
Тэтгэмжийн даатгал	7,997,000.00	7,222,600.00	774,400.00	90.32
ҮОМШӨ-ний даатгал	3,998,500.00	3,610,100.00	388,400.00	90.29
Ажилгүйдлийн даатгал	3,998,500.00	3,610,100.00	388,400.00	90.29
Эрүүл мэндийн даатгал	15,994,000.00	14,424,200.00	1,569,800.00	90.19
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,433,300.00	31,721,751.00	11,711,549.00	73.04
Гэрэл, цахилгаан	14,145,300.00	12,532,651.00	1,612,649.00	88.60
Түлш, халаалт	26,148,000.00	18,408,000.00	7,740,000.00	70.40
Цэвэр, бохир ус	3,140,000.00	781,100.00	3,589,900.00	24.88
Нормативт зардал	74,999,500.00	70,404,836.00	4,594,664.00	93.87
Хоол, хүнс	74,999,500.00	70,404,836.00	4,594,664.00	93.87
Эд хогшил, урсгал засварын зардал	2,300,000.00	2,300,000.00	-	100.00
Урсгал засвар	2,300,000.00	2,300,000.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,874,300.00	3,849,648.00	24,652.00	99.36
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,874,300.00	3,849,648.00	24,652.00	99.36
Бараа үйлчилгээний бусад зардал	29,416,400.00	28,235,660.00	1,180,740.00	95.99
Бараа үйлчилгээний бусад зардал	22,787,600.00	22,997,060.00	(209,460.00)	100.92
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,628,800.00	5,238,600.00	1,390,200.00	79.03
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,052,378,200.00	1,015,896,567.92	36,481,632.08	92.88
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	906,911,000.00	900,883,900.00	6,027,100.00	99.34
Улсын төсвөөс санхүүжих	906,911,000.00	900,883,900.00	6,027,100.00	99.34
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,733,300.00	34,021,751.00	(34,021,751.00)	-
Орон нутгийн төсвөөс	45,733,300.00	34,021,751.00	(34,021,751.00)	-
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	99,733,900.00	105,000.00	99,628,900.00	0.11
Туслах үйл ажиллагааны орлогоос	105,000.00	105,000.00	-	100.00

Архангай аймгийн Батцэнгэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

санхүүжих				
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	99,628,900.00	80,885,916.92	18,742,983.08	81.19
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	112,314,994.06	112,314,994.06	-	100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,686,094.06	31,429,077.14	(18,742,983.08)	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
Төсвийн байгууллага	1	1	-	100.00
АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23	-	100.00
Удирдах ажилтан	1	1	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	10	10	-	100.00
Үйлчлэх ажилтан	10	10	-	100.00
Гэрээт ажилтан	2	2	-	100.00
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	216	216	-	100.00
Төрийн өмчит СӨБ	216	216	-	100.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 795.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс, 795.0 мянган төгрөгийн алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулаагүй алдаа:

- Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь элэгдлийн зардлын дүн 600.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн. Тайлант онд байгуулсан элэгдлийн дүнгээс үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардалд бүртгэсэн дүн 600.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.
- 2025 оны 5 дугаар сард авсан хөрөнгөнд 195.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална:", 5.1.4 "үнэн зөв байх" гэснийг хэрэгжүүлэн ажиллах, алдааг залруулан тайлагнах зөвлөмжийг өгсөн.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хуулийг хэрэгжүүлэн ажиллах, алдааг залруулан тайлагнах зөвлөмжийг өгсөн.

Аудитаар залруулаагүй 7,236.6 мянган төгрөгийн зөрчил² илэрч, 95.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 7,140.9 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 6 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 8,031.6 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 11,889.0 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1. Хүүхдээ асрах чөлөөтэй байсан эхийг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд үндсэн ажилтнаар тайлагнаж 95.7 мянган төгрөгийн зардал илүү бүртгэж төлсөн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн "7.2.4-т заасан даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авч байх хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, ажил олгогч сар бүр нийгмийн даатгалын зохих санд төлнө" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйгээс нэмэлт зардал гарсныг байгууллагын зардлаар бүртгэсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9-т заасан "энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1. "Балансын урамшуулал олгох тухай" Архангай аймгийн Боловсролын газрын даргын 2025.09.03-ны өдрийн А/38 дугаар тушаалаар "2024 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр Эрхлэгчийн 2025 оны 9 дүгээр сарын 8-ны Б/24 тоот тушаалаар "балансын урамшуулал" няравт 1,105.0 мянган төгрөгийг "улирлын үр дүнгийн урамшуулал"-тай давхардуулан олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

3.2.2. Тайлант онд 290.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд буруу бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 5.1.5-д "хэмжигдэхүйц байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 73 дугаар зүйлийн 2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

3.2.3. Эрхлэгчийн 2025-10-08-ны өдрийн 6/27 тоот тушаалаар тэмцээнд амжилттай оролцсон 11 багш, ажилчдад урамшуулал олгосон.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

3.3. Зөвлөмж

3.3.1. Тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдлийн дүнгээс 600.0 мянган төгрөгөөр элэгдлийн зардлыг илүү бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

3.3.2. 2025 оны 5 сарын 20-нд орлого авсан хөрөнгөнд 195.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.7 "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс" нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Элэгдлийн зардал илүү дүнгээр бүртгэсэн	1	600.0			1	600.0			1	600.0	1	600.0
Элэгдэл дутуу байгуулсан	1	195.0	1	195.0					1	195.0	1	195.0
Нийт дүн	2	795.0	1	195.0	1	600.0	-	-	2	795.0	2	795.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
			Тоо	Дүн	Тоо	Дүн		
НДШ илүү тооцож төлсөн	1	95.7	1	95.7				
Балансын урамшуулал олгосон	1	1,105.0			1	1,105.0		
Тэмцээнд амжилттай оролцогчдод урамшуулал олгосон	1	5,745.9			1	5,745.9		
Үндсэн хөрөнгийг бараа материал дансанд орлого авсан	1	290.0			1	290.0		
Дүн	4	7,236.6	1	95.7	3	7,140.9	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Албан шаардлага		Тоо	Дүн
				Тоо	Дүн		
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансанд байршуулах ёстой мэдээллийг хугацаа хоцроосон	1		1			
	Дүн	1		1			